



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 1/71

Шивээговь сум

Малын тэжээлийн ургамал тариалах
 ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар “Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай” тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Сумын 2022 оны төсөвт зохицуулалт хийх тухай” 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Малын тэжээлийн ургамал тариалах” ажлыг 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 07 дугаар сарын 21-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. “Малын тэжээлийн ургамал тариалах” ажлыг зохион байгуулж, хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Маналмаа

(2 дугаар багийн Засаг дарга)

Д.Отгонбаатар

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан

мэргэжилтэн)

Т.Өлзийбуд

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

О.Отгонбаяр

(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

3.Сумын 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Арвайн үр” худалдан авахад 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн “Малын тоо толгойд ногдох албан татварын зардал”-аас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

4.Зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж, бэлчээр нутгийн малчдын бүлгийг оновчтой зохион байгуулан чанартай гүйцэтгэж, тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Ч.Сугармаа)-д, хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг 2 дугаар багийн Засаг дарга (Д.Маналмаа)-д, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ